# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр Дугаар 09 Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Уламжлалт анагаах ухааны төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,662,000 /нэг сая зургаан зуун жаран хоёр мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 276,666.72 /хоёр зуун далан зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө/-ний үлдэгдэл өртөгтэй 10 нэр төрлийн хавсралтад дурдсан хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Уламжлалт анагаах ухааны төвийн дарга (Х.Чирчинсүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх.

2.2 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын
12-ний өдрийн 09 тогтоолын хавсралт

Уламжлалт анагаах ухааны төвийн актлах хөрөнгийн мэдээлэл

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Данснаас хасах болсон шалтгаан | Актлах төрөл /1.Устгах, 2. Худалдах, 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах,4. Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Компютерын ширээ | 09.01.01 | ш | 1 | 135,000 | 135,000 | 135,000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан | Устгах |
| 2 | Хатаагч | 18.12.31 | ш | 1 | 20,000 | 20,000 | 20,000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан эвдэрсэн | Устгах |
| 3 | Хивсэнцэр | 09.01.01 | ш | 1 | 43,000 | 43,000 | 43,000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан | Устгах |
| 4 | Гутал арчигч | 18.12.31 | ш | 1 | 120,000 | 120,000 | 79,999.96 | 40,000.04 | Ашиглалтын хугацаа дууссан | Устгах |
| 5 | Epson к200 принтер | 19.12.27 | ш | 1 | 355,000 | 355,000 | 118,333.32 | 236,666.68 | Хороо татахаа больсон эвдэрсэн | Устгах |
| 6 | Принтер 2013 | 18.12.31 | ш | 1 | 80,000 | 80,000 | 80,000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан эвдэрсэн | Устгах |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шатсан . Ашиглалтгүй болсон | |
| 5 | Дэлгэцтэй өсгөгч , спикер /хар / /хятад/ | 2017.12.26 | ш | 1 | 200000 | 200000 | 200000 | 0 | Ашиглалтын хугацаа дууссан. Циркийн дугуйланд хэрэглэж байсан .шатаж эвдэрсэн . | актлах |
| Дүн | | | | 20 | | 1,126,000 | 842499.92 | 283500.08 | | |
| Нийт | | | | 37 | | 1,313,500 | 1,029,999.92 | 283,500.08 | | |